



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020. 04. 16 № 01

Г Асуулга тавих тухай Т

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-ийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар Танд дараах асуултыг тавьж байна.

Дэлхий дахиньг хамраад байгаа "Ковид -19" вирусийн тархалтын улмаас Монгол Улсад 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын 62 дугаар тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдал тогтоож, шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нэг талаас энэхүү цар тахлыг Монгол Улсад тархаалгүй барихад чухал нөлөө үзүүлсэн боловч гадаад улсуудад байнга болон түр оршин сууж буй Монгол Улсын олон мянган иргэд эх орондоо эргэн ирж чадахгүй байдалд хүрч, тухайн орондоо эд хөрөнгө, сэтгэл санаа, эрүүл мэндээр хохирч, нөхцөл байдал хүндэрсэн байдалтай байгаа тухай мэдээлэл, хүсэлт, гомдол ихээр гарч байна.

Тэдгээр иргэдээ эх орондоо буцаан ирүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын талаар Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсаас гадаад улсуудад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд эх орондоо ирэх хүсэлтэй бөгөөд зайлшгүй шаардлагатай иргэдээ бүртгэхээс эхлээд багагүй алдаа гаргасан тухай, боломж бололцоогоор хавгүй илүү улс төрчид, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд, хөрөнгөлөг хүмүүс тэдгээр хүнд нөхцөлд байгаа иргэдээс урьтан тусгай үүргийн нислэгүүдээр ирсэн тухай, тэр ч бүү хэл тусгай үүргийн нислэгт багтаах нэрийдлээр авлига нэхсэн, авсан байж болзошгүй гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийн тухай мэдээллүүд нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18-д Монгол Улсын иргэн "улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.", энэхүү "...үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн өдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан. Өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон хугацаанд гадаад улсуудад дээрх дурдсанчлан гацсан байгаа Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө хууль зүйн үндэслэлгүйгээр зөрчигдсөн Үндсэн хуулийн зөрчлийн шинжтэй нөхцөл байдал үүсээд байна гэж үзэж байна.

202000037

Гадаад улсуудаас иргэдээ татан авах үйл ажиллагаа 6 дугаар сараас эхлэн эрчимжиж байгаа боловч эх орондоо эргэн ирэх боломжгүй, тухайн гадаад улсад оршин суух эрхгүй, амьжиргаагаа залгуулах орлогын эх үүсвэргүй, нийгмийн болон, эрүүл мэндийн даатгал, баталгаагүй, өвчин зовлон, хагацал, харуусалд нэрвэгдсэн Монголчуудын нөхцөл байдал өдрөөс өдөрт хүндэрсээр байна.

Монгол Улсад ч, дэлхий дахинд ч эдийн засаг, санхүүгийн хямрал гүнзгийрч байгаа энэ үед монголын төр, Монгол Улсын Засгийн газар Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, эдгээр иргэдийнхээ төлөө илүү их анхаарал тавьж, боломжит, оновчтой бүх арга хэмжээг яаралтай, илүү эрчимтэй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд миний бие Монгол Улсын Их Хурлын гишүүний хувиар Танаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хүсэж байна. Үүнд:


- Гадаад улсуудад гацсан байгаа Монгол Улсын иргэдийг эх оронд нь эргүүлэн авч ирэх үйл ажиллагаанд төрийн үйл ажиллагааны суурь зарчмуудыг хангаж ажиллах, уг үйл ажиллагааг бүгдэд ил тод, тэгш, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай, аливаа ялгаварлан гадуурхалгүй зохион байгуулах;
- Энэхүү үйл ажиллагаанд хэн, ямар хяналтыг ямар үр дүнтэйгээр тавьж байгаа, цаашид ямар бодлого баримтлах тухай, хэзээ хүртэл хилээ хаах, өндөржүүлсэн бэлэн байдлыг хадгалах тухай зэрэг мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, дэлгэрэнгүй мэдээлэх;
- Шинжлэх ухаан, тоон мэдээлэл, логикт үндэслэн хорио цээрийн дэглэмийн хугацаанд иргэдийг тусгаарлах байрны асуудлыг яаралтай шийдвэрлэх бүх боломжуудыг судлах, ашиглах, Тухайлбал, шинээр баригдсан эх, хүүхдийн төв эмнэлгийн байрыг ашиглах, иргэдийн санхүүгийн боломжоос хэтэрсэн буюу өдрийн 50 000 төгрөгөөс хэтэрсэн зардал шаардсан аж ахуйн нэгжүүдэд зөрүү мөнгөн хөрөнгийг төрөөс гарган санхүүжүүлэх гэх мэт арга замыг эрэлхийлэх;
- Монгол Улсаас гадаад улсуудад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд иргэдээ, ялангуяа эрүүл мэнд, санхүүгийн хувьд хүнд байдалд орсон иргэдээ онцгой анхаарч, эрх тэгш, шуурхай үйлчилгээгээр ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, авлигын шинжтэй үйлдлүүд гаргуулахгүй байхад анхаарч ажиллах;
- Монгол Улсын иргэний агаарын тээврийн компаниудын нөөц бололцоо үнэхээр хүрэлцэхгүй тохиолдолд гадаад улсуудын ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын хүсэлтийг судалж, нислэгийн тоог нэмэгдүүлэх;
- Гадаадад гацсан иргэдийг эх орондоо авчрахад болон тухайн орондоо амьжиргааны наад захын хэрэгцээгээр хангагдах боломжийг бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх;
- “Ковид-19” вирусээр үүсгэгдсэн цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд зарцуулж буй төсвийн болон хандивын хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг ил тод болгох, зарцуулалтыг эрэмбэлж оновчтой болгох;
- Зөвхөн хорих, хаших, хязгаарлах гэх мэт механик аргаар асуудлыг шийдэхээр оролдож байгаа нь хангалттай хамгаалалт биш тул энэхүү цар тахал гэнэт тархсан тохиолдолд олон нийт хэт сандралд автах гэх мэт эрсдэл байгааг онцгой анхаарч, ийм нөхцөлд хэрэгжүүлэх арга хэмжээний тодорхой төлөвлөгөө боловсруулж нийтэд мэдээлэх зэрэг хамаарна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн
39.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хувийг Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Т.ДОРЖХАНД



2020000037